

**Петро Матад Лимитед (“Петро Матад” эсвэл “Компани” гэх)**

**ЕСБХБ-ны Захиалгын мэдэгдэл болон Шууд захиалгууд хийгдэж буй байдал**

2010 оны 9-р сарын 16-нд Петро Матадын хийсэн мэдээллийн дараагаар Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ) өнөөдөр тус компаний нэг бүр нь 0.01 ам.долларын үнэтэй 3,367,003 ширхэг шинэ энгийн хувьцааг (“Хувьцаа”) тодорхой нөхцөлтэйгээр нэг бүрийг нь 135 пенсийн (2.08 ам.доллараар) үнээр захиалахаа (“ЕСБХБ-ны Захиалга) мэдэгдсэн болохыг зарлаж байгаадаа баяртай байна. ЕСБХБ-наас ойролцоогоор 7 сая ам. долларын захиалга хийгдсэнээр тус компаний 9-р сард босгосон хөрөнгийн нийт дүн нь ойролцоогоор 54 сая ам. доллар болж байгаа юм.

*Хугацааны хуваарь*

Тус компаниас 9-р сарын 16-нд хийсэн мэдэгдэлд заасан шууд захиалгуудын дагуу гаргасан 8,843,675 хувьцаануудыг арилжаалах хүсэлтийг Альтернатив хөрөнгө оруулалтын зах зээл (АХОЗЗ) байгууллагад гаргаад байна. Тэдгээр хувьцаануудын арилжаа нь 2010 оны 9-р сарын 30-ны өдрийн өглөөний 8.00 цагт эхлэнэ.

ЕСБХБ-ны захиалгын дагуу хувьцаа гаргалтыг тус бүрт тусдаа явуулах бөгөөд энэ талаар цаашдын мэдээллийг зохих үед нь өгөх болно.

*Гаргасан хувьцаанууд*

Уг шууд захиалгын хувьцаануудыг гаргаснаар ЕСБХБ-ны захиалгаас өмнөх байдлаар тус компаний гаргасан хувьцаануудын тоо 179,185,324 ширхэг болох юм.

Хуваарилагдсаныхаа дараа эдгээр шинэ хувьцаанууд нь одоогийн байгаа хувьцаануудтай бүхий л талаараа ижилхэн зэрэглэлтэй байх болно.

*Шинээр Хувьцаа гаргаснаар томоохон хувьцаа эзэмшилтүүдэд гарах мэдэгдэх шаардлагатай өөрчлөлтүүд*

	Өмнөх хувьцаа эзэмшилт	Шинэ хувьцаа эзэмшилт	Петро Матадаас гаргасан нийт хувьцаат хөрөнгө дахь эзлэх хувь <sup>i</sup>
Петровис ХХК	34,040,032	36,684,262	20.47%

ЕСБХБ-ны захиалганы дараа ЕСБХБ нь 31,741,110 хувьцаа эзэмшиж тус компаний өссөн нийт хувьцаат хөрөнгөгийн 17.4%-ийг эзэмших болно.

Тус компаний захирал Жон Робертсон нь 2010 оны 9-р сарын 16-нд зарласан 103,950 шинэ хувьцаанаас гадна 50,000 шинэ хувьцаа захиалсан болно. Ингэснээр Шууд захиалгуудын дагуу гаргах шинэ хувьцаануудын дараагаар түүний хувьцаа эзэмшилт нь дараах байдалтай байх болно:

Өмнөх хувьцаа эзэмшилт	Шинэ хувьцаа эзэмшилт	Петро Матадаас гаргасан нийт хувьцаат хөрөнгө дахь эзлэх хувь <sup>1</sup>
300,000	350,000	0.20%

*Холбогдох талын гүйлгээнүүд*

ЕСБХБ-нд хувьцаа борлуулах гэж байгаа явдал нь АХОЗЗ-ийн Компаниудын зориулагдсан журмуудын 13 ба 16-р зүйлүүдийн дагуу хамааралтай талын гүйлгээнд тооцогдох ёстой юм. Бие даасан захирлууд нь (Петро Матадын ТУЗ-д ЕСБХБ-ыг төлөөлдөг Мари Эллен Коллинсоос бусад бүх захирлууд) тус компаний нэрийн өмнөөс дэвшүүлсэн зөвлөгч болох Вэстхаус Секюритис Лимитэд компанитай зөвлөлдсөний үндсэн дээр энэхүү гүйлгээний нөхцлүүд нь хувьцаа эзэмшигчдийн хувьд шударга бөгөөд боломжийн гүйлгээ мөн гэж үзэж байгаа болно.

*Шаардлагатай мэдээллийг дараах хаягаар авч болно:*

Петро Матад Лимитед

Дуглас Жэй. МкГэй- Гүйцэтгэх Захирал +976-11-331099

Вэстхаус Секюритис Лимитед

Ричард Бэйти / Петре Нортон +44/0/ 20 7601 6100

*Редакторуудад зориулсан санамж:*

**Петро Матадын тухай**

Петро Матад нь газрын тосны хайгуул болон цаашдын олборлолт, үйлдвэрлэлийг Монгол улсад эрхлэх чиглэлээр ажиллаж байгаа группын толгой компани юм. Тус групп нь Монгол улсын засгийн газартай байгуулсан гурван Бүтээгдхүүн хуваах гэрээнүүдийг дангаараа гүйцэтгэгч байгууллага болно. Гол хөрөнгө нь тус орны алс дорнодод байрлах 14,250 квадрат км талбай бүхий газрын тосны ХХ блокд байгуулсан Бүтээгдхүүн хуваах гэрээт талбай. Нөгөө хоёр 4 ба 5-р блокууд нь Монгол улсын төв хэсэгт байрлах бөгөөд хамтдаа 71,040 квадрат км талбайтай.

Петро Матад Лимитед компани нь Айс оф Мэн арнд 1483-р бүртгэлтэй байгуулагдсан компани бөгөөд албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Байшин, Проспет Хилл, Дуглас, Айс оф Мэн, Ай Эм 1 –ИКю хаягт байрладаг болно.

---

<sup>1</sup> ЕСБХБ-ны захиалгын дагуу хувьцаа гаргахаас өмнөх тооцоогоор